



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/365

Номгон

Шилдэг тохижилттой байгууллагуудыг
шагнаж, урамшуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжаар зарласан “Шилдэг тохижилттой баг, байгууллага” шалгаруулах болзолт уралдаанд шалгарч нэгдүгээр байранд шалгарсан Баянхонгор эрчим хүч ЦТХХК-ийг 5,000,000 (Таван сая) төгрөгөөр, хоёрдугаар байранд шалгарсан Гэгээн сумади сургуулийг 3,000,000 (Гурван сая) төгрөгөөр, гуравдугаар байранд шалгарсан Татварын газрыг 2,000,000 (хоёр сая) төгрөгөөр, тусгай байранд шалгарсан Баянхонгор Нисэх буудал, 5 дугаар сургууль, Өлзийт сумын Ирээдүй цэцэрлэгийг тус тус 1,000,000 (Нэг сая) төгрөгөөр шагнаж, урамшуулсугай.

2. Шагнал, урамшуулалд зарцуулах 13,000,000 (Арван гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ